



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/115

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4 дэх хэсэг, Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 5.15 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Иргэний нисэхийн ерөнхий газрын ажилтан, албан хаагчдын 600 айлын орон сууцны батлагдсан зураг төслийн дагуу барилгын ажлын гүйцэтгэгчтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулах, барилга угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах, дэд бүтцийн эх үүсвэрийн асуудлыг шийдвэрлэх, төслийн удирдах хороо, түүний ажиллах удирдамж, холбогдох санал дүгнэлтийг боловсруулах, салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн
дарга:

Н.Батсайхан
(Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын үүргийг
хавсран гүйцэтгэгч)

Гишүүд:

Д.Одгэрэл
(Агаарын навигаци, нисэх буудлын бодлого
зохицуулалтын газрын Төсөл, хөтөлбөрийн
хэлтсийн дарга)

Э.Мөнх-Эрдэнэ
(Агаарын навигаци, нисэх буудлын бодлого
зохицуулалтын газрын аэродромын мэргэжилтэн)

О.Ган-Эрдэнэ
(Захиргаа, удирдлагын газрын менежер)

П.Батбаяр
(Хууль, эрх зүй, дүрмийн боловсруулалтын газрын
хуулийн мэргэжилтэн)

Б.Амартүвшин
(Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө
оруулалт, захиалагчийн албаны дарга)

Ж.Ганбаатар
(Иргэний нисэхийн үндэсний төвийн Аж ахуйн
үйлчилгээ, дулаан сантехникийн албаны ерөнхий
инженер)

Нарийн бичгийн
дарга:

Д.Мөнхцог
(Иргэний нисэхийн үндэсний төвийн Аж ахуйн
үйлчилгээ, дулаан сантехникийн албаны дарга)

2.Ажлын хэсгийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шуурхай зохион байгуулж, ажлын үр дүнг сар бүр тайлагнаж ажиллахыг ажлын хэсэг (Н.Батсайхан)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Агаарын навигаци, нисэх буудлын бодлого зохицуулалтын газар (Ч.Одгэрэл)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/323 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА